



ᠮᠣᠩᠭᠣᠯ
ᠬᠠᠮᠠᠭᠠᠨ
ᠬᠡᠮᠡᠪᠡᠷᠰᠣᠯᠢᠨ
ᠭᠠᠰᠠᠷ

ДОРНОД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГАЗАР

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

МОНГОЛЫН ТҮҮХ Онлайн сорил-1

10 сарын 26 18.00-19.20

1.

. Мичин хүний хөгжлийн шат дагуу хамгийн сүүлд үүссэнээс нь эхэлж зөв дарааллуулсан хувилбарыг олж дугуйлна уу. /1 оноо/

1. Хомо хабилис
2. Неандерталь
3. Хомо эректус
4. Хомо сапиенс
5. Австролопитек

A. 3,5,1,2,4 B. 4,2,3,1,5 C. 5,1,4,2,3 D. 1,2,3,4,5 E. 2,4,5,1,3

2.

. Монгол нутагт эртний хүн амьдарч байсныг нотлох гол баримт юу вэ? /1 оноо/

- A. Бичгэн сурвалжууд B. Хүн чулуун хөшөө C. Чулуун багаж зэвсэг
D. Хадны сүг зураг E. Хиргисүүр

3.

. Палеолитийн үеийн хамгийн эртний археологийн дурсгал аль нь вэ? /1 оноо/

- A. Хойд цэнхэрийн агуйн хадны зураг
B. Баянхонгор аймгийн Нарийн голын хөндийн бууц
C. Баянхонгор аймгийн Баянлигийн Чихэн агуй
D. Дөрвөлжин булш
E. Буган чулуун хөшөө

4.

. Дэлхийд хамгийн анхны төрт улс хаана үүссэн бэ? /1 оноо/

- A. Энэтхэг B. Хоёр мөрний хөндий C. Египет D. Хятад E. Монгол

5.

. Буган чулуун хөшөөний талаархи бодомжуудаас **буруу** өгөгдлийг олно уу?

/2 оноо/

A. Хүрэл зэвсгийн үеийн дурсгал

B. Бэлчээр нутгийнхаа хил хязгаарыг зааглах зорилгоор босгодог байсан

C. НТӨ XIV-НТӨ VIII зуунд холбогдох дурсгал

D. Өвөг дээдсээ шүтэн тахиx үзлийн улмаас босгодог байсан

E. Буган хөшөөг дотор нь бүтээгдсэн хэлбэр болон тархсан бүс нутгаар нь гурав ангилдаг

6.

Хүрэл зэвсгийн үеийн он цаг аль нь вэ?

/1 оноо/

A. НТӨ III мянган жилээс НТӨ I мянган жил

B. НТӨ II мянган жилээс НТӨ III зуун

C. НТӨ III мянган жилээс НТӨ IV зуун

D. НТӨ II мянган жилээс НТӨ VII зуун

E. НТӨ IV мянган жилээс НТӨ II мянган жил

7.

. Доорхи эртний улсуудын бүлэглэсэн хувилбаруудаас түрэг угсааны улсуудыг зөв ангилсан хувилбарыг олно уу.

/2 оноо/

A. Сяньби, Жужан, Кидан

B. Хүннү, Түрэг, Кидан

C. Түрэг, Уйгур, Киргиз

D. Киргиз, Хүннү, Түрэг

E. Түрэг, Жужан, Кидан

8.

. Улсаа гурван гарт хуваан захирах төр, засаг захиргааны зохион байгуулалт ямар улсаас эхлэлтэй вэ?

/1 оноо/

A. Их Монгол улс

B. Сяньби

C. Жужан

D. Хүннү

E. Түрэг

9.

745-840 оны хооронд оршин тогтнож байсан Уйгур улсын үеийг зууны тоололд шилжүүлсэн зөв илэрхийлэл нь аль нь вэ? /2 оноо/

- A. VI зууны эхэн хагасаас VII зууны II хагас
- B. VII зууны дунд хагасаас VIII зууны дунд хагас
- C. VIII зууны дунд хагасаас IX зууны дунд хагас
- D. VI зууны дунд үеэс VIII зууны дунд үе
- E. VI-VII зуун

10.

Руни бичгийн хамгийн томоохон ямар дурсгал хаанаас олдсон бэ? /1 оноо/

- A. Чин толгойн балгас, Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг
- B. Хар бухын балгасны цогцолбор, Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг
- C. Хэрлэн барс хотын туурь, Дорнод аймаг, Халх гол сумын нутаг
- D. Күль-Тегиний цогцолбор, Архангай аймгийн Хашаат сумын нутаг
- E. Цогтын хадны бичиг, Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг

11.

Кэмү хэмээх бичиг хэрэглэж байсан эртний улс аль нь вэ? /1 оноо/

- A. Жужан
- B. Киргиз
- C. Уйгур
- D. Кидан
- E. Сяньби

12.

Мэргидийн ханлиг хаагуур нутаглаж байсан бэ? /1 оноо/

- A. Сэлэнгийн сав газраар
- B. Онон, Хэрлэн, Туулын сав
- C. Элсэн говийн урдуур
- D. Алтайн нурууны ар, өврөөр
- E. Халх гол орчмоор

16.

- . Арван гурван хүрээний байлдаанд ялсан Жамухын харьяаны олон аймгууд Чингис хаанд ирж нийлсний гол учир юу вэ? /2 оноо/
- A. Жамуха тэдэнтэй дайны олзоо хуваагаагүй тул
 - B. Жамуха уйдамтгай хүн байсан тул
 - C. Чингис хаан тэдэнд эрх мэдэл, эд хөрөнгө амласан тул
 - D. Жамуха харь овгийн хүн байсан тул
 - E. Жамуха Чонос овгийнхныг харгисласан тул

17.

- . “Харайхад минь хөл болж
Хазайхад минь түшиг болж хальтирахад минь тах болж
Халамж тус хүргэхээ хайрт..... минь мэдтүгэй
Энэ бие хэврэг боловч
Эрхэм нэр мөнх шүү
Саруул ухаанаас илүү сайн нөхөр байдаггүй
Мунхаг хилэнгээс илүү муу дайсан байдаггүй
Эрхэм итгэл олон боловч
Энэ бие бүгдээс итгэлтэй
Хайрлах юм олон боловч
Халуун амийг хамгаас хайрлалтай
Хатуужиж явбал хамагт хэрэгтэй
Ариун явбал ашид тустай” хэмээн Чингис хаан хэнд ямар үйл явдал болоход хэлсэн бэ? /2 оноо/
- A. Алга бэхийг Харлагын Арслан ханд хатан болгон өгөхөд
 - B. Ибага бэхийг Жорчидайд соёрхоход
 - C. Чэчэйхэн бэхийг Онгудын Алхуш Дигитхурид соёрхоход
 - D. Уйгурын Идүдэд Алалтун бэхийг хатан болгон өгөхөд
 - E. Тулуйд Сорхогтуныг хатан болгон өгөхөд

18.

. Чингис хааны есөн өрлөгт хамааралгүй хүн аль нь вэ?

/1 оноо/

A. Хархиру B. Боорчи C. Чуу мэргэн D. Хорчи E. Мухулай

19.

. Чингис хаан Хорезмыг байлдан дагуулах аян дайнд явж байхдаа хэнээр Хорезмын Мухамед шахын араас нэхүүлсэн бэ?

/1 оноо/

A. Зэлмэ, Хубилай B. Боорчи, Борохул C. Сүбээдэй, Шихихутуг
D. Зэв, Зэлмэ E. Зэв, Сүбээдэй

20.

. Их Монгол улсын үед Төрийн бэхи ямар үүрэгтэй байсан бэ?

/1 оноо/

A. Их хуралдай хуралдуулах, хаан өргөмжлөх, аян дайнд мордох зэрэг төрийн чухал үйл хэрэг эхлэх өлзийт өдрийг сонгон, цаг, зүг чигийг зааж өгөх
B. Шадар хишигтэн цэргийг захирах, хаанд ойр шадарлах, түшмэдийг шагнах, шийтгэх
C. Улс орны өдөр тутмын хэргийг удирдах, өртөө улааг хариуцах
D. Хааны төрийн тамгыг хадгалах, хамгаалах,
E. Улс орны хэмжээний асуудлыг хэлэлцэж, шийдвэр гарган хаанд айлтгах

21.

. Адилтгах замаар асуултын тэмдэгийн оронд тохирох үгийг доорхи өгөгдлөөс олж дугуйлаарай.

/2 оноо/

Орчин цагт – Хотын захирагч Их Монгол улсын үед -?

A. Захирагч B. Баскак C. Гоо ван D. Даргач E. Чэрби

22.

. Эдгээр хүмүүсээс хэн нь Их Монгол улсад ирж байгаагүй вэ?

/1 оноо/

A. Рашид Ад-дин B. Плано Карпини C. Гильом Рубрук D. Марко Поло
E. Бүгд ирж байгаагүй

23.

. Цэгийн оронд тохирох утгыг олно уу.

/2 оноо/

..... зууны тэргүүн хагаст Ил хаант улсын хаан Францын хаан IV Филиппт захидал илгээжээ.

- A. XIII зууны дунд хагас, Хүлэгү хаан
- B. XIII зууны сүүл хагас, Аргун хаан
- C. XIV зууны эхний хагас, Газан хаан
- D. XIV зууны дунд хагас, Абу Сайд хаан
- E. XIV зууны эхний хагас, Өлзийт хаан

24.

. Хархорум хотын мөнгөн модны тухай мэдээг хэн тэмдэглэн үлдээсэн бэ?

/2 оноо/

- A. Марко Поло
- B. Ата Малык Жувейни
- C. Гильом Рубрук
- D. Рашид Ад-дин
- E. Плано Карпини

25.

. Монголын Алтан Ордны улсын гол нутаг хаана байсан бэ?

/1 оноо/

- A. Шар мөрний эхээр
- B. Ижил мөрний адаг урсгал
- C. Ил тарвагатай орчим
- D. Арал нуурын орчмоор
- E. Орхон гол орчмоор

26.

. Цагадайн улсад хамааралгүй хот аль нь вэ?

/1 оноо/

- A. Самарканд
- B. Ургенч
- C. Отрар
- D. Сарай
- E. Бүгд хамаарна

27.

. Хубилай хаан Японыг хоёр удаа довтлоод эзэлж **чадаагүй** шалтгаан юу вэ?

/2 оноо/

- A. Япончууд эрэлхэг байлдсан
- B. Монгол цэргийн тоо цөөн байсан
- C. Солонгос, Хятад цэргүүд урвасан
- D. Далайн хөлөг онгоц цөөхөн байсан
- E. Далайн хар салхинаас болсон

28.

. Хубилай хаан Монголын эзэнт гүрний төвийг Хятадад шилжүүлснээр ямар үр дагавар гарсан бэ?

/1 оноо/

- A. Монгол нутаг болон дэлхийн эзэнт гүрний нийслэл гэгддэг байсан Хархорум хот улс төрийн ач холбогдлоо алдаж, орхигджээ
- B. Монголыг торгоны зам дайран өнгөрөх болсноор монгол нутаг цэцэглэн хөгжсөн
- C. Ямар нэгэн өөрчлөлт гараагүй
- D. Уугуул монгол Өгөдэйн угсааныхны мэдэлд орж, Хархорумыг умард нийслэл болгосон
- E. Хархорум нь Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудын зангилаа хот болсон

29.

Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудын байгуулагдсан хугацааг зөв харгалзуулна уу. /2 оноо/

- | | | | | |
|---------------------|----------------|----------------|----------------|----------------|
| 1. Юань гүрэн | A. 1256 | | | |
| 2. Цагадайн улс | B. 1271 | | | |
| 3. Алтан Ордоны улс | C. 1221 | | | |
| 4. Ил хаант улс | D. 1242 | | | |
| A. 1d,2a,3b,4c | B. 1c,2b,3a,4d | C. 1a,2d,3c,4b | D. 1b,2c,3d,4a | E. 1b,2d,3a,4c |

30.

Дараах түүхэн бүтээлүүдийг зохиогчтой нь зөв харгалзуулна уу.

/2 оноо/

- | | | | | |
|--|----------------------|----------------|----------------|----------------|
| 1. Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл | A. Марко Поло | | | |
| 2. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх | B. Плано Карпини | | | |
| 3. Монголчуудын түүх | C. Ата Малык Жувейни | | | |
| 4. Орчлонгийн элдэв сонин | D. Гильом Рубрук | | | |
| A. 1a,2b,3c,4d | B. 1c,2d,3a,4b | C. 1d,2c,3b,4a | D. 1c,2d,3a,4b | E. 1b,2a,3d,4c |

31.

. XIV-XVI зууны үеийн жонон цолтой хүн Монголын аль хэсгийг захирдаг байсан бэ?

/1 оноо/

A. Баруун Монгол /Ойрад/

B. Баруун түмэн

C. Ордос түмэн

D. Зүүн түмэн

E. Цахар түмэн

32.

. “Эртний Монголын төрт ёсны хураангуй Алтан товч”-ыг хэн зохиосон бэ?

/1 оноо/

A. Инжинааш

B. Шихихутуг

C. Саган сэцэн

D. Лувсанданзан

E. Зохиогч нь тодорхойгүй

33.

. “Өндөр үүдийг чинь хөнгөн гэж

Өндөр босгыг чинь нарийн гэж

Өнөболд ванд эгихүл

Уурга чинь урт

Хуйв чинь агуу буй.

Намайг уургалж ав.

Чиний үрийг өчүүхэн гэж басаж авахул

Өнөболд ванг уургалж ав

Харь бүрсэн хан хөвгүүн төрж

Хан хөвгүүн чинь халив гэж

Хар биеэ мэдэж эчвээс

Хаа гуяа ханзалсу...” гэж хэн, ямар үйл явдал болоход тангараг өргөсөн бэ?

/1 оноо/

A. Огул Хаймиш хатан, Тулуйн угсааны Өнөболд хаан суухыг завдахад

B. Сорхугтан бэхи, Өгөдэйн угсааны Өнөболд хаан суухыг завдахад

C. Өэлүн үжин, Тайчуудын Өнөболд ван хаан суухыг завдахад

D. Туракина хатан, Тулуйн угсааны Өнөболд хаан суухыг завдахад

E. Мандухай сэцэн хатан, Хасарын угсааны Өнөболд хаан суухыг завдахад

34.

Батмөнх даян хаан Халхыг ямар хан хүүдээ эзэмшүүлсэн бэ?

/1 оноо/

A. Төрболд

B. Улсболд

C. Барсболд

D. Гэрсэнз

E. Гэрэболд

35.

Түвдийн лам Содномжамцад хэн “Далай лам” цолыг өгсөн бэ?

/1 оноо/

A. Лигдэн хутагт хаан

B. Ордосын Хутагтай сэцэн хунтайж

C. Автай сайн хан

D. Түмэн засагт хаан

E. Түмэдийн Алтан хан

36.

Лигдэн хаан Манжийн хаан Нурхачид илгээсэн захидалдаа “Өөрийгөө дөчин түмэн Монголын эзэн”, “түүнийг мөрөн голын хөвөөнд суух гурван түмнийг захирсан өчүүхэн хан” хэмээсэн баримтаас ямар дүгнэлт хийж болох вэ?

/1 оноо/

A. Лигдэн хаан өөрийгөө Манж гүрний хаан, Нурхачийг Өвөрмонголын хантай харьцуулан жишсэн

B. Лигдэн хаан тухайн үеийн хүчний харьцааг бодитоор үнэлсэн.

C. Лигдэн хаан Манжийн хаантай найрамдалтай харьцаатай байх хүслээ илэрхийлсэн

D. Лигдэн хаан өөрийн хүчийг хэт өндөр үнэлж, Манж нарын хүчийг дутуу үнэлсэн

E. Харилцан элч томилох саналаа илэрхийлсэн

37.

Гүүш хан, Цогт хунтайж нарын хоорондоо байлдах болсон шалтгаанд аль хувилбар нь **орохгүй** вэ?

/1 оноо/

A. Түвдэд хяналтаа тогтоохын төлөө

B. Хөх нуурт хяналтаа тогтоохын төлөө

C. Харьяат иргэдээ булаацалдаж, эрх мэдлийн төлөө

D. Түвдийн шашны урсгалуудын төлөө

E. Тодорхой шалтгаан байхгүй

38.

Галдан бошигтын Халхад цөмөрсөн үйл ажиллагааны үр дагаварт **хамааралгүй** зүйлийг ол /1 оноо/
A. Халхын зарим хэсэг Өндөр гэгээнийг дагаж Өвөр монгол руу дүрвэн гарсан
B. Халхын зарим ноёд Галдантай нэгдэж Манжийн эсрэг сөрөн зогссон
C. 1691 онд Халхууд Манжид дагаар ороход хүргэсэн
D. Галдан бошигт өөрийн эсрэг Халх Манжийн нэгдсэн хүчнийг босгосон
E. Халхууд дайны хөлд нэрвэгдсэн

39.

Халх Монголын ноёд Манжид дагаар орох болсон үндсэн шалтгаан юу вэ? /1 оноо/
A. Шарын шашин дэлгэрснээс Халхуудын эрэлхэг дайчин байдал алдагдсан.
B. Манж улс эдийн засаг, цэргийн талаар хүчирхэг байсан
C. Хаант Орос улс Халхад цэргийн тусламж үзүүлээгүй учраас
D. Галдан бошигт Халхын ноёдыг Манж руу хөөж оруулснаас
E. Манжийн хаан Халхын ноёдод эд баялаг амласан учраас

40.

1755 онд Монголын түүхэнд ямар томоохон үйл явдал болсон бэ? /1 оноо/
A. Баруун Монгол манжид эзлэгдсэн
B. Халх Монгол манжид эзлэгдсэн
C. Халх Монгол манжаас салж тусгаар тогтносон
D. Өвөр Монгол манжид эзлэгдсэн
E. Томоохон үйл явдал тохиолдоогүй

41.

Зүүнгар улс буюу Ойрадууд Манжид эзлэгдэх болсон үндсэн шалтгаан юу вэ? /1 оноо/
A. Орос улс Манжид цэргээр тусалсан
B. Зүүнгар улсын эрхшээлд байсан Дундад азийн орнуудын бослого
C. Зүүнгар улсын нөлөө бүхий ноёд Манжид урвасан
D. Зүүнгар улсад гарсан цэцэг өвчний улмаас
E. Манжийн цэргийн хүчийг зогсоох хүчин Төв азид байгаагүй

42.

42. Манжийн эрхшээлийн үеийн Халхын дөрвөн аймгийг газар зүйн байрлалаар нь зүүн талаас эхэлж нэрлэнэ үү? /2 оноо/

- A. Түшээт хан аймаг B. Засагт хан аймаг C. Сайн ноён хан аймаг D. Сэцэн хан аймаг
 A. B,D,C,A B. A,C,D,B C. B,C,A,D D. D,A,C,B E. Тохирох хариулт алга

43.

Энэхүү зураг манжийн есөн эрүүний алинд орох вэ?

- A. Төөнүүрдэх
 B. Хонгор азарга
 C. Шаахайдах
 D. Сараалж
 E. Туйвандах



/1 оноо/

44.

Манжийн эрхшээлийн үеийн хошуу захирагчийг хэн гэдэг байсан бэ? /1 оноо/

- A. Мэйрэн B. Захирагч C. Занги D. Засаг ноён E. Залан

45.

“...Ер нь аливаа юманд цаг хэмжээ хугацаагүй нь огт үгүй. Энэ байдал нь мөн цаг болсны тул болой. Одоо Монгол овогтон бүгдээр нийлж, өөртөө улс болон тогтнож, шашнаа мандуулан, бусдын эрх мэдэл, дарлагдах зовлон зүдгүүрийг үзэхгүй цаг болсон....” хэмээн Монголын ард түмэнд хэн уриалсан бэ? /2 оноо/

- A. Чин ван Ханддорж B. Да лам Цэрэнчимэд C. VIII Богд Жавзундамба хутагт
 D. Сайн ноён хан Намнансүрэн E. Хайсан гүн

46. Олноо өргөгдсөн Монгол улсын төрийн дээд одон аль нь вэ?

/1 оноо/

- A. Чингисийн одон B. Эрдэнийн очир одон C. Алтан гадас одон D. Богдын одон
E. Цусан гавъяаны одон

47.

“Өөртөө засан тогтнох эрх”-ийг олон улсын улс төрийн хэллэгээр юу гэж нэрлэдэг вэ?

/1 оноо/

- A. Дагуул эрх
B. Статус кво
C. Сувернитет эрх
D. Автономит эрх
E. Доминион

48.

1915 оны Хиагтын бага хурлаар шийдэгдсэн асуудлуудыг ялган нэрлэнэ үү.

/2 оноо/

1. Монгол улсад Баргыг нэгтгэхээр болсон
 2. Монгол улс Дундад Иргэн улсын автономит болж хувирсан
 3. Хятадын пүүсүүдэд тавьсан монголчуудын өрийг цайруулахаар болсон
 4. Хятадаас Хүрээ болон Улиастай, Ховдод цагдан сэргийлэх цэрэг суулгахаар тохиролцов
 5. Богд хааныг жилд нэг удаа Бээжинд очиж бараалхаж байхыг тусгасан.
 6. Дундад Иргэн улсаас Хүрээнд суух сайдыг томилж ажиллуулахаар болсон
 7. Өвөр монголчуудыг Халх монголд олноор суурьшихыг зөвшөөрсөн
 8. Монгол улсад зөвхөн Ховдын хязгаарыг нэгтгэхийг зөвшөөрсөн
- A. 2,6,8 B. 5,6,1 C. 2,5,8 D. 3,5,8 E. 7,3,1

49.

Доор дурьдсан үйл явдлуудаас аль нь 1921 оны хувьсгалтай холбогдох вэ?

/1 оноо/

- A. Ноёдын бүлгэм Зүүн хүрээний бүлгэмтэй нэгдэж МАН-ыг байгуулав
B. 1919 онд ноёдын бүлгэмийн гишүүд ЗОУ-аас тусламж авахаар болов
C. Ардын журамт цэрэг Хиагтыг гамин цэргээс чөлөөлөв
D. Богд хааныг хэмжээгүй эрхт хаанаар өргөмжлөв
E. Дундад Иргэн улстай харилцан туслалцах гэрээ байгуулав

50.

Манжийн үеийн засаг захиргааны нэгжид аль нь хамаарахгүй вэ?

/1 оноо/

A. Сум

B. Баг

C. Аймаг

D. Хошуу

E. Арван

51.

Олноо өргөгдсөн Монгол улсын Засгийн газрын яамдын тэргүүн сайдуудыг зөв харгалзуулна уу.

/2 оноо/

1. Шүүн таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд

A. Түшээ гүн Чагдаржав

2. Гадаад хэргийг эрхлэн шийтгэгч яамны тэргүүн сайд

B. Далай ван Гомбосүрэн

3. Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд

C. Эрдэнэ ван Намсрай

4. Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд

D. Чин ван Ханддорж

5. Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд

E. Да лам Цэрэнчимэд

A. 1d,2a,3e,4c,5b

B. 1a,2c,3e,4b,5d

C. 1c,2d,3b,4e,5a

D. 1c,2d,3e,4a,5b

E. 1a,2d,3c,4b,4e 5f

52.

Монгол улсыг Бүгд найрамдах засаглалд шилжүүлсэн үндсэн хууль аль нь вэ?

/1 оноо/

A. Ийм агуулгатай үндсэн хууль батлагдаагүй

B. 1940 оны үндсэн хууль

C. 1960 оны үндсэн хууль

D. 1992 оны үндсэн хууль

E. 1924 оны үндсэн хууль

53.

Дараах засаг захиргааны өөрчлөлтийг хугацаатай нь зөв тохируулна уу.

/2 оноо/

1. Улсын нийслэлийг Улаанбаатар хэмээн нэрлэв

A.1922 он

2. Аймгуудын тоог нэмж 13 болгов

B.1911 он

3. Их Хүрээг Нийслэл хүрээ хэмээн нэрлэв

C.1931 он

4. Аймгуудын нэрийг өөрчилж уулын нэрүүдээр нэрлэв

D.1924 он

A. 1d,2c,3b,4a

B. 1c,2d,3a,4b

C. 1d,2a,3c,4b

D. 1a,2d,3c,4b

E. 1b,2a,3d,4c

54.

. Энэхүү түүхэн хүмүүсийн уулзалт Монголын түүхэнд ямар ач холбогдолтой вэ?

/2 оноо/

- A. Берлиний бага хурал, БНМАУ-ын тусгаар тогтнолыг Их гүрнүүд хүлээн зөвшөөрсөн
- B. Тегераны бага хурал, Их гүрнүүд БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхээр тохиролцсон
- C. Подстамын уулзалт, БНМАУ Герман улсад дайн зарлахаар болсон
- D. Ялтын бага хурал, Их гүрнүүд БНМАУ-ын статус квог хүлээн зөвшөөрсөн
- E. Вашингтоны бага хурал, БНМАУ-тай холбоотой асуудал хэлэлцээгүй



55.

Дараах монголын соёлын нэрт зүтгэлтнүүдээс хэн нь өөр мэргэжилтэй вэ?

/2 оноо/

- | | | |
|--------------|---------------|------------|
| A. Л.Мөрдорж | B. А.Амгалан | C. Б.Шарав |
| D. Г.Одон | E. О.Цэвэгжав | |

56.

Эдгээрээс хэн нь Монгол улсын ерөнхий сайдын албыг хашиж байгаагүй вэ?

/1 оноо/

- | | | |
|-----------------|------------------|-----------------|
| A. Ж.Эрдэнэбат | B. Н.Энхбаяр | C. Р.Амаржаргал |
| D. Р.Гончигдорж | E. Ч.Сайханбилэг | |

2.1.

. Дараах хаадуудыг цолтой зөв харгалзуулна уу.

/6 оноо/

- | | |
|---------------|--------------|
| A. Хутагтай | 1. Төгстөмөр |
| B. Нигүүлсэгч | 2. Шэлүн |
| C. Далай | 3. Хубилай |
| D. Сэцэн | 4. Элбэг |
| E. Билэгт | 5. Өгөдэй |
| F. Усхал | 6. Аюушридар |

2.2.

. Дараах түүхэн үйл явдлуудыг эзэнтэй нь зөв харгалзуулна уу?

/6 оноо/

- | | |
|---|------------------------------|
| A. Мин улсын Ин Цзун хааныг олзлов | 1. Хүлэгү |
| B. Ил хаант улсыг байгуулав | 2. Манлай баатар Дамдинсүрэн |
| C. Соёмбо үсгийг зохиов | 3. Автай сайн хаан |
| D. Эрдэнэ зуу хийдийг байгуулав | 4. Эсэн тайш |
| E. Өвөрмонголыг эзлэв | 5. Өндөр гэгээн Занабазар |
| F. Таван замын цэргийн ерөнхий
жанжнаар томилогдов | 6. Абахай хаан |

2.3.

. XX зуунд өрнөсөн дараах үйл явдлуудыг болсон он цагийн дарааллаар нь /хамгийн эхэнд болсон үйл явдлаас эхлэн 1-6 гэж дугаарлана/ эрэмбэлнэ үү. /6 оноо/

- A. Улс төрийн хэлмэгдүүлэлт оргилдоо хүрэв
- B. МАН Богд хаантай тангарагийн гэрээ байгуулав
- C. XX зууны зэвсэгт бослого
- D. БНМАУ-ын хоёр дахь үндсэн хууль батлагдав
- E. Хамжлагат ёсыг халав
- F. Богд хаан нас барав

2.4.

Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү? /6 оноо/

Чингис хаан Их Монгол улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь Баруун, Төв, Зүүн гэсэн гурван их түмэнд хувааж, Төвийн түмнийг А захирч, түүний мэдэлд В нутаг хамрагджээ. Баруун түмнийг С захирч, D орчмын нутаг түүнд харъяалагджээ. Монголын зүүн хэсэг E орчим нутаг Зүүн түмэнд харъяалагдаж, F захирч байв.

1. Мухулай
2. Боорчи
3. Наяа
4. Хянганы нурууны
5. Гурван голын сав
6. Алтайн нурууны

1	B	1
2	C	1
3	B	1
4	C	1
5	B	2
6	D	1
7	C	2
8	D	1
9	C	2
10	D	1
11	E	1
12	A	1
13	E	2
14	A	2
15	D	1
16	E	2
17	A	2
18	D	1
19	E	1
20	A	1
21	D	2
22	A	1
23	E	2
24	C	2
25	B	1
26	D	1
27	E	2

28	A	1
29	D	2
30	C	2
31	B	1
32	D	1
33	E	1
34	D	1
35	E	1
36	D	1
37	C	1
38	B	1
39	D	1
40	A	1
41	C	1
42	D	2
43	E	1
44	D	1
45	C	2
46	B	1
47	D	1
48	A	2
49	C	1
50	B	1
51	D	2
52	E	1
53	A	2
54	D	2
55	A	2
56	D	1

2.1	A2, B4, C5, D3, E6, F1	6
2.2	A4, B1, C5, D3, E6, F2	6
2.3	A5, B1, C4, D6, E2, F3	6
2.4	A3, B5, C2, D6, E4, F1	6